



**ОРХОН АЙМГИЙН  
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ**

Ш.Отгонбилэгийн гудамж, Оюут баг,  
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61025  
Утас: (976)7035 8569, Факс: (976) 7035 2811  
Цахим шуудан: Bayanundur@sith.or.gov.mn

2028.01.30 № 01/43

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.МӨНХБАЯР ТАНАА**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
ээлжит III Хурлын хуралдаанаас гарсан тогтоолуудыг  
хавсралтаар хүргүүлэв.

Хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт <sup>15</sup> хуудастай.

ДАРГА



Ө.ЭРДЭНЭБАТ



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 19

Баян-Өндөр сум

Баян-Өндөр сумын Засаг даргын  
2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1."Баян-Өндөр сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2.Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж, хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн IV улиралд багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Б.Мөнхбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн  
Ээлжит III хуралдааны 19... дугаар  
тогтоолын хавсралт

## **БАЯН-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Хөтөлбөрийг боловсруулахад Орхон аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 оны ээлжит сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон улс төрийн намуудын мөрийн хөтөлбөрийн хүрээнд нэг талаас иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах, нөгөө талаас иргэн төвтэй үр дүнд суурилсан, ухаалаг шийдлийг ашиглан сумаа хөгжүүлэхийг тус хөтөлбөрийн удирдлага болгон зорилтуудаа дэвшүүллээ.

Хөтөлбөр хэрэгжсэнээр Баян-Өндөр сумын хүний хөгжлийг хангасан, амьдрах таатай орчин бүрдэж, төрийн үйлчилгээний шуурхай байдал хангагдаж, төр иргэний хамтын ажиллагаа, ил тод, нээлттэй байдал дээшилнэ.

### **НЭГ. ХОЙД БҮСИЙН ХӨГЖИЛД ОРОН НУТГИЙН ОРОЛЦОО**

#### **1.1. Сум, орон нутгийн хөгжил**

1.1.1. Шилжин ирж суурьших иргэдэд ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төрийн үйлчилгээг үзүүлэхэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

1.1.2. Аялал жуулчлалыг бүс орон нутгийн онцлогт түшиглэн төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлэхэд хамтран ажиллана.

1.1.3. Бүс нутгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй эдийн засгийн өсөлтийг дэмжсэн аливаа арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

#### **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ**

#### **2.1. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан**

2.1.1. Гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог дээшлүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, салбар дундын уялдаа холбоог сайжруулан залуучуудын хөгжил, идэвхижсэн хандлага оролцоог дэмжих, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.1.2. Хүүхдийг болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэн, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна.

2.1.3. Хүүхэд харах болон өдөр өнжүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

2.1.4. Залуучуудын боловсрол, хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.1.5. Иргэд, олон нийтийн сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө болон сэтгэл заслын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд хамтран мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллана.

2.1.6. Ахмад настны хөдөлмөр эрхлэлт, амьжиргааг дэмжих, эрүүл мэнд, асаргаа сувилгааны чанар, хүртээмж сайжирч, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулна.

2.1.7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэргэжлийн сургалт, дадлагажуулалт, хөдөлмөр эрхлэлтэд зуучлах үйлчилгээг өргөжүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

2.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, барилга байгууламжийн стандартыг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад мөрдүүлж орчны дэд бүтцийн хүртээмжийг сайжруулахад хамтран ажиллана.

## **2.2. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж**

2.2.1. Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, иргэдэд бизнес эрхлэх бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.2. Зорилтот бүлгийн ажилгүй иргэд, оюутан, залуучууд, ахмадуудыг түр болон цагийн ажлын байранд холбон зуучлах ажлыг ажил олгогч, ажилтанд нийцтэй байдлаар зохион байгуулахад хамтран ажиллана.

2.2.3. Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт тогтолцоонд тулгуурлан хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

2.2.4. Жижиг, дунд, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн чадавхыг сайжруулж, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжихэд хамтран ажиллана.

## **2.3. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг**

2.3.1. Нийтийн биеийн тамир, спортоор хичээллэгчдийг дэмжиж, спортын арга хэмжээг иргэдэд сурталчилж, хүн амын дунд эрүүл, идэвхитэй амьдралын хэв маягийг хэвшүүлнэ.

## **2.4. Эрүүл мэнд**

2.4.1. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдааг хангасан байна.

2.4.2. Иргэний эрүүл мэндийн боловсрол, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог төлөвшүүлж, иргэдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

2.4.3. Эрүүл мэндийн байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

## **2.5. Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол**

2.5.1. "Хамгийн сайн сургууль, цэцэрлэг-Гэрт ойр сургууль, цэцэрлэг", "Нэг ээлж, цөөн хүүхэдтэй анги" үйл ажиллагааг хэрэгжүүлж, цэцэрлэг, сургуулийн бүлэг дүүргэлтийг багасгахад хамтран ажиллана.

2.5.2. Боловсролын салбарын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.5.3. Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшлийг сайжруулж, эрх хамгаалал, аюулгүй байдлыг хангах, эх хэл, үндэсний өв уламжлал, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах олон талт үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

2.5.4. Бүх насны иргэдийг насан туршдаа суралцахуйн үйлчилгээнд хамруулах "Суралцагч сум, байгууллага" болох олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

## **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО**

### **3.1. Хот төлөвлөлт**

3.1.1. Сумын гудамж талбайн нэр, эд хөрөнгийн хаягжилтыг сайжруулан хаягийн нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлнэ.

3.1.2. Иргэдийн орлогод нийцсэн болон ногоон амины орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ипотекийн, ногоон зээлийн бодлогоор дэмжиж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

### **3.2. Дэд бүтэц**

3.2.1. Сумын хэмжээнд үерийн хамгаалалтын далан сувгийн төлөвлөлтийг шинэчлэн боловсруулан шинээр барих ажлыг үе шаттайгаар хийж, ашиглалтыг сайжруулна.

3.2.2. Сумын хэмжээнд цэвэрлэх байгууламжид системийн шинэчлэл хийж, бохирын гуравдугаар коллекторыг ашиглалтад оруулан усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэхэд хамтран ажиллана.

3.2.3. Хотын цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэхэд шаардлагатай 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, шугам, сүлжээг өргөтгөн, ухаалаг удирдлагын систем нэвтрүүлж, цахилгаан хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

### **3.3. Тээвэр, авто зам**

3.3.1. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмж сайжирч, автозам, замын байгууламж нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

3.3.2. Нийтийн тээврийн үйлчилгээнд парк шинэчлэлт хийж, ухаалаг системийг нэвтрүүлэн, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

3.3.3. Хотын дотор болон амралт, зугаалгын бүсүүдэд явган хүн, унадаг дугуйн замыг нэмэгдүүлнэ.

### **3.4. Хүнс, хөдөө аж ахуй**

3.4.1. Хүн амын хүнсний чанар, аюулгүй байдал хангагдахад салбар уялдааг хангана.

3.4.2. "Хүнсний хангамж аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангахад салбар дундын уялдааг хангана.

3.4.3. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, малын халдварт өвчингүй тайван байдлыг хадгална.

3.4.4. "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд хоршоодыг дэмжин, малчдыг үйлдвэрлэгч өрх болгон хөгжүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.

3.4.5. Малыг үүлдэр угсааг сайжруулж, эрчимжсэн аж ахуйг дэмжин мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3.4.6. Мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллана.

### **3.5. Байгаль орчин, ногоон тогтвортой хөгжил**

3.5.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, ногоон Эрдэнэт хөтөлбөрийг эрчимжүүлж, эко системийн тэнцвэртэй байдлыг хадгалах санаачилгыг дэмжинэ.

3.5.2. Усны нөөцийг хомсдолоос сэргийлж, хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.5.3. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагуудын нөхөн сэргээлтийг эрчимжүүлнэ.

3.5.4. Орчны чанар, төлөв байдлыг тодорхойлж, "Цэвэр агаартай хот" төслийг хэрэгжүүлэн орчны бохирдлыг бууруулахад хамтран ажиллана.

3.5.5. Хог хаягдлын менежментийг сайжруулна.

### **3.6. Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл**

3.6.1. Үндэсний өв соёл, ёс заншил, уламжлалаа хадгалан, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, орон нутгийн онцлогт нийцсэн аялал жуулчлал хөгжиж, иргэдэд үзүүлэх, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

3.6.2. Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хадгалах, хамгаалах, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлэн сурталчлах ажлыг олон талын оролцоотой зохион байгуулна.

3.6.3. Соёл, урлагийн байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.6.4. Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулна.

### **3.7. Шинжлэх ухаан, инновацид суурилсан Ухаалаг хот**

3.7.1. Орон нутагт шинээр бий болох инноваци, бүтээгдэхүүний нэр төрөл, ажлын байрыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

3.7.2. Бүс, орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэл, кластер хөгжүүлэх инновацийн төсөл, гарааны компанийг инкубатор, технологи дамжуулах үйлчилгээгээр дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

### **4.1. ДӨРӨВ. ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЗАСАГЛАЛ**

4.1.1. Хүний эрхийн үндэсний комисс болон бусад байгууллагуудтай хүний эрхийг хангах чиглэлээрх хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.1.2. Аж ахуйн нэгж байгууллагууд үйл ажиллагаандаа хүний эрхийг дээдлэх, иргэд эрхээ эдлэх нөхцөлийг хангаж байгаа эсэхэд төрөөс тавих хяналтыг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдааг ханган ажиллана.

4.1.3. Жендерийн эрх тэгш байдлыг хангах, бэхжүүлэх, хамгаалах, жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар бүх нийтийн жендерийн талаарх боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

4.1.4. Хууль тогтоомжийг сурталчлан бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулна.

4.1.5.Төрийн захиргааны байгууллагаас шийдвэр гаргахдаа хүний эрхэд суурилсан хандлагыг удирдлага болгон хүний эрхийн зөрчлөөс сэргийлж ажиллана.

#### **4.2.Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдал**

4.2.1.Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог сайжруулж, хуулиар хориглосноос бусад мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

4.2.2.Иргэний нийгэм, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, оролцоо, санаачилгыг дэмжих бодлогыг баримтлан төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

#### **4.3. Цахим засаглал, төрийн үйлчилгээ**

4.3.1.Чадахуйн зарчимд суурилсан төрийн албыг бэхжүүлж, төрийн үйл ажиллагааны хурд, бүтээмж дээшилж, төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангана.

4.3.2.Төрийн байгууллагын цахим дэд бүтцийг хөгжүүлж, мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг нэвтрүүлж шийдвэр гаргах үйл явцыг шуурхай, ил тод болгоход хамтран ажиллана.

4.3.3.Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж багийн байр шинээр барьж ашиглалтад оруулахад хамтран ажиллана.

4.3.4.Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, сургаж хөгжүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулна.

4.3.5.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулж, хариуцлагыг дээшлүүлнэ.

#### **4.4. Амар тайван, аюулгүй сум**

4.4.1.Олон нийтийг авлигаас ангид байлгах, шударга ёсыг шаардах, авлигыг үл тэвчих сэтгэлгээ, хандлагыг иргэн бүрд төлөвшүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

4.4.2.Эрүүл, аюулгүй орчныг бий болгох зорилгоор дэвшилтэт технологи бүхий камерын хяналтын нэгдсэн системийг суурьшлын бүсийн 80 хувьд хүргэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллана.

4.4.3.Аймгийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

4.4.4.Согтууруулах ундааны эргэлтэд тавих хяналтыг сайжруулж, архи дан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд хамтран ажиллана.

#### **4.5. Батлан хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдал**

4.5.1.Аймгийн батлан хамгаалах болон гамшгаас хамгаалах чадавх бэхжиж, гамшгийн бэлэн байдлыг хангагдахад хамтран ажиллана.

4.5.2.Гамшиг, аюулт үзэгдэл, ослыг зарлан мэдээлэх системийг өргөжүүлж, эрсдэлийн мэдээлэлд суурилсан гамшгаас хамгаалах удирдлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэн, гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоог дэмжиж ажиллана.

4.5.3.Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд хамтран ажиллана.

№	Бүлэг	Үйл ажиллагаа	Зорилтын тоо
1.	ХОЙД БҮСИЙН ХӨГЖИЛД ОРОН НУТГИЙН ОРОЛЦОО	1. Сум, орон нутгийн хөгжил	3
2.	ХҮНИЙ ХӨГЖИЛ	1. Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан	8
		2. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж	4
		3. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	2
		4. Эрүүл мэнд	3
		5. Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол	4
3.	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	1. Хот төлөвлөлт, Газар зохион байгуулалт	2
		2. Дэд бүтэц	3
		3. Тээвэр, авто зам	3
		4. Хүнс, хөдөө аж ахуй	6
		5. Байгаль орчин, ногоон тогтвортой хөгжил	5
		6. Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл	4
		7. Шинжлэх ухаан, инновацад суурилсан Ухаалаг хот	2
4.	ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ЗАСАГЛАЛ	1. Хүний эрх, эрх чөлөө	5
		2. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, ил тод байдал	2
		3. Цахим засаглал, төрийн үйлчилгээ	5
		4. Амар тайван, аюулгүй хот	4
		5. Батлан хамгаалах, гамшгийн үеийн бэлэн байдал	3
	4	18	68 зорилттой байна.



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 20

Баян-Өндөр сум


Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 13/03 дугаар тогтоолоор баталсан “Баян-Өндөр сумын хэсгийн ахлагчийн хөгжлийн дэд хөтөлбөр”-ийн нэршлийг “Баян-Өндөр сумын багийн ажилтны хөгжлийн дэд хөтөлбөр” болгон өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 21

Баян-Өндөр сум

Баян-Өндөр сумын иргэдийн санаачилгыг  
дэмжих хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1."Баян-Өндөр сумын иргэдийн санаачилгыг дэмжих хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2."Баян-Өндөр сумын иргэдийн санаачилгыг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж, хагас жилээр Хурлын зөвлөлийн хуралд, бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг Засаг дарга (Б.Мөнхбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн  
Ээлжит III хуралдааны 21- дугаар  
тогтоолын хавсралт

## **“БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН САНААЧИЛГЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР”**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Төр иргэний хамтран ажиллах үйл ажиллагааг бэхжүүлэх, иргэдийн гаргасан санал санаачилгыг дэмжин ажиллах, ажлын зардлыг санхүүжүүлж, гүйцэтгэлийг тайлагнахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

### **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт**

#### **2.1. Дэд хөтөлбөрийн зорилго:**

2.1.1.Иргэдийн ая тухтай, сэтгэл ханамжтай, аюулгүй амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, иргэн төвтэй олон нийтийн оролцоотой төрийн үйлчилгээг бий болгох.

#### **2.2. Дэд хөтөлбөрийн зорилт:**

2.2.1.Иргэдийн санаачилга, оролцооны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, дэмжих ажлыг таниулан сурталчлах, иргэдэд мэдээ мэдээлэл өгөх, арга туршлагыг сайжруулах,

2.2.2.Төр, иргэдийн хоорондын уялдаа холбоог сайжруулж иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоог хангах,

2.2.3.Иргэдийн санаачилга, оролцоогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн тэгш, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх,

2.2.4.Иргэдийн санал санаачилгаар дамжуулан нийгмийн эерэг хандлагыг бий болгох,

2.2.5.Нийтийн сайн сайхны төлөө хүн бүрийн оролцоог хангах.

### **Гурав. Хэрэгжүүлэх зарчим, хугацаа, хамрах хүрээ**

#### **3.1.Дэд хөтөлбөрийн зарчим:**

3.1.1.Хариуцлагатай, ил тод байх

3.1.2.Тэгш хүртээмжтэй байх

3.1.3.Нийтийн эрх ашиг зөрчигдөхгүй байх

3.1.4.Хувийн ашиг сонирхлоос ангид байх

#### **3.2.Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:**

3.2.1.Хөтөлбөр батлагдсан өдрөөс эхлэн 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

#### **3.3.Дэд хөтөлбөрийн хамрах хүрээ:**

3.3.1.Баян-Өндөр сумын нийт иргэд

### **Дөрөв. Ажил гүйцэтгэх**

4.1.Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг иргэдийн ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх боломжтой эсэхийг судалж холбогдох байгууллагуудын нөөц болон чадамжийг тодорхойлж Засаг даргын зөвлөлд танилцуулж шийдвэрлэнэ.

4.2.Иргэдийн ирүүлсэн хүсэлт нь ажлын хүрэх үр дүн тодорхой, нийтийн эрх ашгийг хангасан байна. Нэмэлтээр техник, тоног төхөөрөмж, эд материал, шаардлагатай тохиолдолд шатахууны тооцооллыг хавсаргаж өгнө.

4.3. Иргэн ажил гүйцэтгэхээс өмнөх ба дараах зургийг авч баримтжуулсан байна.

4.4. Тоног, төхөөрөмжийг ашиглах тохиолдолд хариуцлагын гурвалсан гэрээг байгуулна.

4.5. Дэмжлэг нь 5,000,000.00 хүртэлх төгрөгийн өртөгтэй байна.

4.6. Иргэнд олгох дэмжлэгт цалин, урамшуулал олгогдохгүй зөвхөн сайн дурын үндсэн дээр ажлыг хийж гүйцэтгэнэ.

#### **Тав. Хүрэх үр дүн**

5.1. Иргэдийн санаачилгыг дэмжсэнээр иргэдийн оролцоот үйл ажиллагааг зохион байгуулах арга барилыг сайжруулан, эрхээ эдэлж, үүрэг, хариуцлагаа ухамсарлан орон нутгийн хөгжилд өөрийн санал санаачилгыг оруулж, төсөл хөтөлбөрт хамрагдаж, төр ба иргэний харилцаа холбоог бэхжүүлснээр иргэдийн сэтгэл ханамж нэмэгдэн, амьдрах хүрээлэн буй орчны нөхцөл байдал сайжирсан байна.

#### **Зургаа. Хориглох заалт**

6.1. Тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар гүйцэтгүүлэх, хүн амь нас эрүүл, мэндэд хохирол учруулж болзошгүй санал санаачилгыг хүлээж авахгүй.

#### **Долоо. Хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх**

7.1. Иргэдийн санаачилгыг дэмжих хөтөлбөр нь жил бүрийн Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй хавсран Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст давхар хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэнэ.

7.2. Хөтөлбөрийн үр дүн санхүүгийн тайлан мэдээллийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлантай хамтатган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

#### **Найм. Санхүүжилт**

8.1. Хөтөлбөрийг тухайн жил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төсвөөр санхүүжүүлнэ.

8.2. Хэрэгжүүлж буй арга хэмжээ, төслийн санхүүжилтийг 80 хувийг ажил эхлэхэд олгох бөгөөд үлдэгдэл санхүүжилт бөлох 20 хувийг ажил гүйцэтгэсний дараа олгоно.

#### **Ес. Хөрөнгийн тайлагналт, хяналт тавих**

9.1. Хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллага, ажилтан хөрөнгийн зарцуулалтын тайланг уг арга хэмжээг хэрэгжүүлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор гаргаж, тухайн шатны Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

9.2. Хөрөнгийн зарцуулалтын тайланг санхүүжүүлсэн зардал, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсөвтэй зэрэгцүүлэн гаргаж, байгууллагын дарга, нягтлан бодогч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулан холбогдох баримтыг хавсаргана.

9.3. Хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ.

9.4. Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн нэгж нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулна.

9.5. Хөрөнгийн зарцуулалтад санхүү, төрийн сангийн нэгж, төсвийн захирагч тус тус хяналт тавина.

9.6. Хурлын Хороодын ажлын чиг үүрэгтэй холбоотой арга хэмжээнд холбогдох Хороод хяналт тавьж ажиллана.

## **Арав. Хариуцлага**

10.1. Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийн дагуу хууль зөрчихгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах үүргийг байгуулагдсан Ажлын хэсэг хүлээнэ.

10.2. Энэ журмыг зөрчсөн байгууллага, иргэн, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 22

Баян-Өндөр сум

Баян-Өндөр сумын “Болзошгүй аваарын зардлын журам”-ыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баян-Өндөр сумын “Болзошгүй аваарын зардлын журам”-ыг шинэчлэн баталсугай.

2. Болзошгүй аваарын зардлын журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, хагас бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг сумын Засаг дарга (Б.Мөнхбаяр)-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 19/02 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн  
Ээлжит III хуралдааны дугаар  
тогтоолын хавсралт

## **БОЛЗОШГҮЙ АВААРЫН ЗАРДЛЫН ХӨРӨНГӨ ГАРГАХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Журмыг урьдчилан төлөвлөх болон нарийвчлан тооцож, төсөвт тусгах боломжгүй барилга байгууламжийн гэмтэл, инженерийн шугам сүлжээний зарим гэмтэл, технологийн доголдлыг засварлаж сэргээн босгох, ашиглалтын хэвийн байдлыг хангах, гамшигт хор уршгийн улмаас үүдэн гарах аваар ослоос урьдчилан сэргийлэх, гамшигт үзэгдлээс үүссэн аваарыг зогсоох, сэргээн засварлах зэрэг гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй хойшлуулшгүй ажлын зардлыг санхүүжүүлж, гүйцэтгэлийг тайлагнахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2 Болзошгүй аваарын зардлыг цаашид “Зардал” гэнэ.

1.3 Зардлын төсвийг жил бүр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

### **ХОЁР. ЗАРДЛЫН ЗОРИУЛАЛТ**

2.1 Зардлаас гаргах хөрөнгийн дээд хэмжээ 20 хүртэлх сая төгрөг байх бөгөөд дараах үйл ажиллагаанд зарцуулна. Үүнд:

2.1.1 Гамшгийн эрсдэлийг бууруулах, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цар тахал, хортон шавж, мэрэгч тархахаас урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах зардал;

2.1.2 Хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй ажлыг зохион байгуулахад шаардагдах зардал;

2.1.3 Зам, даваа хаагдсан тохиолдолд яаралтай арга хэмжээ авахад шаардагдах зардал;

2.1.4 Нийтийн эзэмшлийн зам, талбай, үерийн далан, суваг шуудуу, гүүрэн гарцад эвдрэл гэмтэл үүсэх, айл өрхийн орц гарц хаагдсан тохиолдолд шаардагдах зардал;

2.1.5 Гэнэтийн аюулын улмаас сум, багийн, нэгдсэн байрны барилга байгууламж, шугам, сүлжээ, эрчим хүчний эвдрэлд гэмтэл гарсан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн сэргээн засварлахад шаардагдах зардал;

2.1.6 Сумын нутаг дэвсгэрт өвөлжилт, хаваржилт хүндэрсэн тохиолдолд зэргэлдээх аймаг, сумтай хамтран ажиллах, өвс тэжээлийн нөөц хүрэлцэхгүй тохиолдолд бэлтгэх ажилд шаардагдах зардал;

2.1.7 Байгалийн давагдашгүй хүчин зүйл, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, цар тахал, хортон шавж, мэрэгч тархах, нийтийг хамарсан осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах ажлыг

санхүүжүүлэх зардал;

## ГУРАВ. САНХҮҮЖИЛТ

3.1 Уг зардлыг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

3.2 Хэрэгжүүлж буй арга хэмжээ, төслийн санхүүжилтийг 60 хувийг ажил эхлэхэд олгох бөгөөд үлдэгдэл санхүүжилт болох 40 хувийг ажил гүйцэтгэсний дараа олгоно.

## ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ

4.1. Тус суманд ирүүлсэн хүсэлт, мэдээллийн дагуу хариуцсан мэргэжилтэн, холбогдох байгууллагатай хамтран тухайн газарт үзлэг шалгалт хийж, ажлын зураг, төсөв, холбогдох баримт бичигтэй танилцаж хууль тогтоомж, заавар, журамтай нийцэж байгаа эсэхийг хянаж, ирүүлсэн ажилд авах арга хэмжээний саналыг боловсруулж сумын Засаг даргатай зөвшилцөнө.

4.2. Тухайн байгууллага /өмчлөгч, ашиглагч, хариуцагч/-аас ирүүлсэн Онцгой байдлын байцаагчийн болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт эсвэл Засаг даргын шийдвэрийг үндэслэж засварлах ажлыг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний дараа Засаг даргын захирамжийг үндэслэн хөрөнгийг гаргана.

4.3. Гамшгийн онц нөхцөл байдал зарласан, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй бол тухайн үед үүссэн ослыг зогсоох, засварлаж хэвийн байдалд оруулахаар тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагатай шууд гэрээг байгуулж болно.

4.4. Зарцуулагдах зардлыг тооцохдоо орон нутгийн жишиг үнийн хэмжээгээр тооцно.

4.5. Ажил гүйцэтгэх этгээдийг холбогдох журмын дагуу сумын Онцгой комиссын хурлаар сонгон шалгаруулж, Баян-Өндөр сумын Засаг даргатай гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлд Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэн байнгын хяналт тавьж ажиллана.

4.6. Батлагдсан ажлын явцад болон ажил дууссаны дараа гүйцэтгэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас үүсээгүй гэмтэл гарсан үед мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн нэмэлт ажлын санхүүжилтийг тооцож сумын Засаг даргын захирамжаар батлан нэмэлт санхүүжилт олгож болно.

4.7. Ажлыг төрийн болон орон нутгийн өмчит мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд материал, механизм, тээврийн зардал НӨАТ, ажлын төсөвт тусгана.

4.8. Ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд шууд зардлын дүнгээр тооцож, НӨАТ, ажил гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх зардлыг төсөвт тусгана.

4.9. Гүйцэтгэсэн ажилд Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг хяналт тавьж, хөрөнгийн шинж чанартай бол тухайн байгууллагын дансанд бүртгэнэ.

4.10. Гүйцэтгэсэн ажлыг Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хариуцсан мэргэжилтэн холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын санхүү албанд хүргүүлнэ.

4.11. Ажлын үйл явцыг баримтжуулан зардлын зарцуулалтын тайлан мэдээг гаргаж, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын санхүү албанд хүргүүлэх ажлыг холбогдох мэргэжилтэн хариуцна.

4.12. Гүйцэтгэсэн ажлыг хүлээн авах ажлын хэсэгт тухайн багийн иргэдээс сонгогдсон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч орж хяналт тавьж ажиллаж болно.

#### **ТАВ. ТАЙЛАГНАХ**

5.1. Хөрөнгийн зарцуулалт, үлдэгдлийн талаарх мэдээллийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр сумын Засаг дарга тайлагнана.

#### **ЗУРГАА .ХАРИУЦЛАГА**

6.1. Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлж, хууль зөрчихгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах үүргийг холбогдох мэргэжилтнүүд холбогдох хуулийн хүрээнд хүлээнэ.

6.2. Энэ журмыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 23

Баян-Өндөр сум

“Дээд боловсролын сургалтын  
байгууллагын суралцагчдад олгох оюутны  
тэтгэлэгт хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баян-Өндөр сумын “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад олгох оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад олгох оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж, хагас жилээр Хурлын зөвлөлийн хуралд, бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Мөнхбаяр)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн  
Ээлжит III хуралдааны 23. дугаар  
тогтоолын хавсралт

## **ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧДАД ОЛГОХ БАЯН-ӨНДӨР СУМЫН ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Тус хөтөлбөр нь Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийг төгссөн, суралцах хугацаандаа сурлага, урлаг, спортоор бусдыгаа манлайлж тэргүүлсэн, нийгмийн идэвх зүтгэлтэй, суралцах чин хүсэл эрмэлзэлтэй суралцагчийг урамшуулж дэмжих мөн Орхон аймаг Баян-Өндөр суманд үйл ажиллагаа явуулдаг /магадлан итгэмжлэгдсэн/ их дээд сургуулийг сонгон суралцах хүсэл зорилготой, ирээдүйн чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд энэхүү хөтөлбөрийн гол зорилго оршино.

1.2.Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусламжийг “Оюутны тэтгэлэг” гэнэ.

### **Хоёр. Суралцагчийн тэтгэлэг**

2.1.Тус тэтгэлэг нь Баян-Өндөр суманд үйл ажиллагаа явуулж буй /магадлан итгэмжлэгдсэн/ Их, дээд сургуулийн бакалаврын өдрийн хөтөлбөрийг сонгон суралцах суралцагчид энэхүү хөтөлбөрийн тэтгэлэг олгогдоно.

2.2.Оюутны тэтгэлэг нь сургалтын төлбөрийн 2.500.000 /хоёр сая таван зуу мянга/ төгрөг хүртэлх байна.

2.3.Оюутны тэтгэлэг хүссэн суралцагчийн холбогдох материалыг жил бүрийн 08 дугаар сарын 22-ны дотор Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын албанд хүлээлгэн өгнө.

2.4.Оюутны тэтгэлэг авах хүсэлт ирүүлсэн иргэдийн материалыг хянан судалж, сонгон шалгаруулах ажлыг сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хариуцан зохион байгуулж, шаардлага хангасан материалыг сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **Гурав. Тэтгэлэг олгоход тавигдах шаардлага**

3.1.Оюутны тэтгэлэг хүсэгч нь Орхон аймгийн Баян-Өндөр сумын Ерөнхий боловсролын сургуулийг төгссөн суралцагч байх.

3.2.Тус тэтгэлэгт бүтэн өнчин, хагас өнчин, эцэг, эх хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа 70-100% алдсан гишүүнтэй өрхийн суралцагч бол давуу эрх эдлэнэ.

3.3.Оюутны тэтгэлэг хүсэгч нь Баян-Өндөр суманд үйл ажиллагаа явуулдаг /магадлан итгэмжлэгдсэн/ их дээд сургуулийг сонгон суралцагч, нийгмийн идэвх зүтгэлтэй, сурлага, урлаг спортоор бусдыгаа манлайлагч, суралцагч байх.

3.4.Их дээд сургуульд оюутны тэтгэлэг хүссэн суралцагч нь элсэлтийн ерөнхий шалгалтад /500 ба түүнээс дээш/ оноо авсан байх.

3.5. Оюутны тэтгэлгийг суралцагчдын элсэлтийн ерөнхий шалгалтын оноог харгалзан үзэж олгох ба үргэлжлүүлэн /II.III.IV/ курст суралцагчийн голч дүн 3.0-аас дээш байж тэтгэлэг нь үргэлжлүүлэн олгогдоно.

3.6. Оюутны тэтгэлэг хүсэгч нь боловсролын зээлийн сан болон бусад сургалтын тэтгэлэгт, хөтөлбөрт хамрагдаагүй байх.

#### **Дөрөв. Бүрдүүлэх бичиг баримт**

4.1. Оюутны тэтгэлэг хүсэгч нь дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

4.2. Хүсэлт /баталсан маягтын дагуу/

4.3. Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж

4.4. Бүрэн дунд боловсролын гэрчилгээ

4.5. I курст элсэн суралцагч нь сургуульд зохих журмын дагуу элссэнийг гэрчлэх эрхийн бичиг /цаашид II, III, IV, курст үргэлжлүүлэн суралцагчийн дүнгийн тодорхойлолт голч дүн 3.0 -аас дээш байна/

4.6. Эцэг эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон иргэний үнэмлэхний хуулбар

4.7. Багийн Засаг даргын тодорхойлолт (оршин суугаа хаяг)

4.8. Тус хөтөлбөрийн 3.2 дэх заалтын шаардлагыг хангасан тохиолдолд холбогдох бичиг баримтыг хавсаргах.

4.9. Тус хөтөлбөрийн 2.5 дахь заалтын шаардлагыг хангасан тохиолдолд амжилт гаргасныг нотлох баримт бичиг.

#### **Тав. Санхүүжилт**

5.1. Оюутны тэтгэлэг хүссэн суралцагчийн сургалтын төлбөрийг Их дээд сургуулийн сургалтын дансруу шилжүүлнэ.

Жич: /Иргэний дансанд шилжүүлэхийг хориглоно/

5.2. Тэтгэлэгт хамрагдах шийдвэр гарсан суралцагчдын оюутны тэтгэлгийг их дээд сургуулийн сургалтын дансанд 11 дүгээр сарын 01-ний дотор шилжүүлэх ажлыг Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс хариуцан ажиллана.

5.3. Оюутны тэтгэлгийг тухайн онд батлагдсан төсөвт багтаан хөтөлбөрийн шаардлага хангасан суралцагчдад олгоно.

5.4. Оюутны тэтгэлэг нь зөвхөн суралцаж байх хугацаанд олгогдоно.

#### **Зургаа. Хариуцлага**

6.1. Тэтгэлэгт хамрагдсан суралцагчтай хариуцлагын гуравласан гэрээ байгуулж, гэрээг зөрчсөн тохиолдолд буруутай этгээд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

#### **Долоо. Хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх**

7.1. Хөтөлбөрийн үр дүн санхүүгийн тайлан мэдээллийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлантай хамтатган сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

#### **Найм. Бусад**

8.1. Оюутны тэтгэлэгтэй холбогдон гарсан маргааныг холбогдох хууль тогтоомж болон дүрэм, журмаар зохицуулна.

8.2. Хугацаа хожимдуулсан болон баримт бичгийн бүрдэл дутуу материалыг хүлээн авахгүй.

---oOo---



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 24

Баян-Өндөр сум

Мал амьтныг шимэгчтэх өвчнөөс  
урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний  
2025 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баян-Өндөр сумын 2025 оны мал, амьтны шимэгч өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо, төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахыг сумын Засаг дарга (Б.Мөнхбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн  
Ээлжит III хуралдааны 24... дугаар  
тогтоолын хавсралт

**МАЛ СҮРГИЙГ ШИМЭГЧТЭХ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,  
ЭМЧЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Арга хэмжээний нэр	Хамрагдах малын тоо			Бүгд
		Бог	Бод	Амьтан	
1	Туулга	31.0	3.4	1.0	35.4
2	Боловсруулалт	30.0	5.8		35.8
3	Угаалга	44.0	6.0		50.0
	<b>Нийт</b>	<b>105.0</b>	<b>15.2</b>	<b>1.0</b>	<b>121.2</b>

---oOo---



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 25

Баян-Өндөр сум

Багийн амьжиргааг дэмжих зөвлөл  
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 08/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн үйлчилгээний чаңар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Баян-Өндөр сумын 2000-аас дээш хүн амтай багуудад нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах эсэх асуудлаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх үүрэг бүхий Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийг ажиллуулахыг зөвшөөрсүгэй.

2.Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл ажиллуулах багуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Багийн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Мөнхбаяр), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга (Х.Эрдэнэбат) нарт даалгасугай.

ДАРГА

Э.ЭРДЭНЭБАТ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025  
оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Ээлжит III  
хуралдааны 25- дугаар тогтоолын хавсралт

**Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл ажиллах  
багуудын жагсаалт**

1. Зэст
2. Оюут
3. Уурхайчин
4. Хүрэнбулаг
5. Уртбулаг
6. Согоот
7. Дэнж
8. Бүрэнбүст
9. Шанд
10. Наран
11. Цагаанчулуут
12. Булаг
13. Баянцагаан, Малчин
14. Говил
15. Рашаант
16. Эрдэнэ
17. Баянбулаг
18. Их залуу
19. Даваат
20. Уртын гол
21. Яргуйт
22. Найрамдал
23. Чандмань
24. Баян-Овоот
25. Чингэл

---oOo---



ОРХОН АЙМАГ  
БАЯН-ӨНДӨР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар д6

Баян-Өндөр сум


Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын нөхөн сонгуулийн санал авах  
өдрийн тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, 9.9 дэх хэсгийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн санал авах өдрийг 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн Ням гарагт байхаар тов тогтоосугай.

2. Энэ тогтоолыг 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Э.ЭРДЭНЭБАТ